



БАГАХАНГАЙ ДУУРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 8/200

Улаанбаатар хот

Дүүргийн 2 дугаар хорооны цогцолбор байрны цахилгааны кабель солих ажилд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалтын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.2 дугаар хорооны цогцолбор байрны цахилгааны гадна шугамд гэмтэл үүссэний улмаас тог цахилгаангүй болж төрийн үйлчилгээ иргэдэд хүрэх ажил удаашрах нөхцөл байдал үүсэж байгаа тул цахилгааны кабелийг шинэчлэх ажлыг зохион байгуулсугай.


2. Цахилгааны кабельд шаардагдах 1,082.600 (Нэг сая наян хоёр мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Цахилгааны кабелийг шинэчлэх ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, дууссанаас хойш 10 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг 2 дугаар хороо (Б.Батзориг)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД





Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 дүгээр сарын 06 ны өдрийн
0/00 дугаар захирамжийн хавсралт

**2 ДУГААР ХОРООНЫ ЦОГЦОЛБОР БАЙРНЫ ЦАХИЛГААНЫ КАБЕЛЬ
СОЛИХ АЖИЛД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ**

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Кабель АВВГ 35х3+1	м	110	8,500	935,000
2	Түлш	л	40	3690	147,600
Нийт үнэ:					1,082,600